




NIBank

ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК



2021

Жилийн тайлан



АГУУЛГА

Эдийн засгийн орчин

Банкны салбарын тойм

Компанийн танилцуулга

Компанийн бүтэц

Төлөөлөн удирдах зөвлөл

Удирдлагын баг

Нийгмийн хариуцлага

Хураангуй санхүүгийн тайлан

Аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан

Хараат бус аудиторын тайлан

ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

Монгол Улсын эдийн засгийн сэргэлт 2021 онд сул байв. Эдийн засаг 2021 оны эхэнд эрчимтэй сэргэж байсан боловч гадаад худалдааны салбарт учирсан хүндрэл бэрхшээлээс шалтгаалан эдийн засгийн өсөлт сүүлийн улирлуудад зогсонги байдалд оров.

Ийнхүү 2020 онд эдийн засгийн өсөлт 4.4 хувиар агшаад байсан бол 2021 онд 1.4 хувиар өсжээ.

Гадаад худалдааны саатал эхлэхээс өмнө оны эхний улиралд нүүрс олборлолт эрчимжиж, зэсийн хүдрийн агууламж сайжирсан болон үйлчилгээний салбар сэргэсэн нь эдийн засгийн өсөлтийг голлон дэмжжээ.

Үйлчилгээний салбар (эрүүл мэнд, мэдээлэл харилцааны технологи, худалдаа, зочид буудал болон ресторан, түүнчлэн санхүүгийн үйлчилгээ) 2021 оны ДНБ-ий 1.8 нэгж хувийг бүрдүүлсэн нь 2021 оны 2 дугаар хагасаас Ковид-19-тэй холбоотой дотоод хязгаарлалтуудыг сулруулж эхэлсний илрэл юм.

Харин эсрэгээрээ аж үйлдвэрийн салбар зогсонги байдалд орсон бол хилийн боомтуудын доголдлоос шалтгаалан барилгын материалын нийлүүлэлт тасалдаж барилгын салбар уналтад оров. Малын өвчин болон цаг агаарын тааламжгүй нөхцөлөөс шалтгаалан хөдөө аж ахуйн салбар мөн агшсан байна.

ОНЦЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

 ДНБ +1.4%

 ИНФЛЯЦИ 13.4%


 ГАДААД ХУДАЛДАА
2398 сая ам.доллар

18.4 их наяд төгрөг
Нийт хадгаламж

10.03%
Чанаргүй зээлийн хувь

4366.06 сая ам.доллар
Гадаад валютын нөөц

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ


Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан эдийн засгийн ихэнх салбарууд зогсонги байдалд шилжсэнтэй холбоотой өсөлт эдийн засгийн өсөлт 1.4 хувьтай гарлаа. Хүн амын вакцинжуулалт, тээвэр ложистикийн сэргэлтийн хурдаас хамааран эдийн засаг сэргэх хандлагатай байна. Үүнээс гадна Ковид-19 цар тахлын дараах эдийн засгийн сэргэлтийн хурдад төрөөс авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ, тохируулга чухал нөлөөтэй.

Банкны салбарын үзүүлэлт харьцангуй тогтвортой, өсөлттэй байлаа. Банкны салбарын нийт актив жилийн эцэст өмнөх сараас 2.3 хувиар нэмэгдэж ДНБ-ийн хэмжээнд ойртлоо. Геополитик, гадаад худалдаанаас шалтгаалж санхүүгийн зах зээлд тодорхой бус байдал, эрсдэл байсаар байна.

Сүүлийн 2 жил гаруйн хугацаанд мөнгөний болон сангийн тэлэх бодлогын хүрээнд ААН-үүдэд хөнгөлөлттэй зээлүүд олгож эхэлсэн. Зээлийн хуваарьт өөрчлөлт оруулсан иргэд, ААН-үүд, ажлын байрыг дэмжих зээл авсан ААН-үүд 2022 онд зээлээ төлж эхлэх бөгөөд ингэснээр чанаргүй зээл нэмэгдэх магадлалтай.

Банкны тухай хуулийн хүрээнд, системийн нөлөө бүхий 5 банк IPO гаргахаар бэлтгэл ажлаа хангаж буй хэдий ч таамаглаагүй гадаад хүчин зүйлээс үүдэлтэй олон улсын санхүүгийн цочролтой үед иргэд, хөрөнгө оруулагчид энэ үйл явцад бэлэн байх эсэх нь эргэлзээтэй хэвээр байна.

ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ:



ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ:



ОНЦЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД:



40.1 их наяд ₮
Нийт актив



10.03%
Чанаргүй зээлийн хувь



20.7 их наяд ₮
Нийт зээлийн багц




18.3 их наяд ₮
Нийт хадгаламжийн үлдэгдэл

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид харилцагчдаа дээдлэн, итгэлцлийг эрхэмлэн, санхүүгийн цогц үйлчилгээг шинэлэг хэлбэрээр баяжуулан түгээж, тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулсан бүтээлч банк байна.


АЛСЫН ХАРАА

Үндэсний баялаг бүтээгчдийн түнш, хөрөнгө оруулалтаараа тэргүүлэгч банк байна.





КОМПАНИЙН БҮТЭЦ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банкны Төлөөлөн удирдах зөвлөл/ТУЗ/ нь 5 гишүүний бүрэлдэхүүнтэй. ТУЗ-ийн даргыг түр орлон гүйцэтгэгчээр хатагтай С.Оргилмаа, гишүүдээр Б.Тулга, Хидэтоши Тоноока, Ж.Цэдэнрагчаа, П.Ариунаа нарын бүрэлдэхүүнтэй Банк санхүүгийн салбарын арвин туршлагатай мэргэжилтнүүд ажиллаж байна. Үндэсний хөрөнгө оруулалтын банкны ТУЗ-ийн дарга болон гишүүд нь банкны хувьцаа эзэмшигч биш болно.

С.Оргилмаа

*ТУЗ-ийн даргыг түр орлон
гүйцэтгэгч*

Б.Тулга

ТУЗ-ийн гишүүн

Ж.Цэдэнрагчаа

ТУЗ-ийн гишүүн

Хидэтоши Тоноока

ТУЗ-ийн гишүүн

П.Ариунаа

ТУЗ-ийн хараат бус гишүүн

М.Цэндпүрэв

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

УДИРДЛАГЫН БАГ

Г.Тогтохбаатар

Гүйцэтгэх захирлын орлогч

О.Одгэрэл

*Эрсдэл, хуулийн
газрын захирал*

А.Удвал

*Санхүү бүртгэл, тайлагналын
газрын захирал*

Ш.Дашбалжир

*Мэдээлэл технологийн газрын
захирал*

Ж.Мөнхзаяа

*Үйл ажиллагаа, хүний нөөцийн
удирдлагын газрын захирал*

О.Төгсжаргал


*Дотоод аудитын
хэлтсийн захирал*

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА




Банк үүсгэн байгуулагдсаны 15 жилийн ойн баярыг тохиолдуулан банкны ажилтнууд “Сайн үйлсийн аян – 15 жил” хандивын аян өрнүүлсэн бөгөөд нийт 2,295,000 төгрөгийг цалингаасаа цуглуулж, Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн жирэмсэн болон 0-3 хүртэлх насны хүүхэдтэй эмэгтэйчүүдэд КОВИД-19 коронавирусын эмийн багцыг худалдан авч өгөх ажлыг зохион байгуулсан.


НИЙТ АКТИВ




ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ



ЧАНАРГҮЙ ЗЭЭЛ



ХҮҮГИЙН ОРЛОГО



ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Сая.Төгрөгөөр

Балансын зүйл		2020-12-31	2021-12-31
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,004.4	1,675.0
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	0.0	0.0
1.3	Хөрөнгө оруулалт	2,538.6	2,344.0
1.4	Зээл (цэвэр дүнгээр)	29,605.7	6,986.4
1.4.1	Хэвийн зээл	9,370.5	1,472.3
1.4.2	Чанаргүй зээл	84,519.3	66,530.1
1.4.6	Зээлийн хойшлогдсон төлбөр	-12.9	-6.0
1.4.7	Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	1,579.5	196.5
1.4.8	Зээлийн эрсдэлийн сан	-65,850.8	-61,206.4
1.5	Дериватив санхүүгийн хөрөнгө	0.0	0.0
1.6	Бусад санхүүгийн хөрөнгө	30,909.7	0.3
1.7	Бусад санхүүгийн бус хөрөнгө	1,027.6	58,673.4
1.8	Үндсэн хөрөнгө	11,577.1	10,599.2
1.9	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	2,123.2	2,069.7
1.10	Борлуулах зориулалттай хөрөнгө	4,956.3	3,401.5
1.11	Биет бус хөрөнгө	16,567.3	16,519.7
1.12	Нийт хөрөнгийн дүн	101,310.0	102,269.3
2	ӨР ТӨЛБӨР		
2.1	Харилцах	112,688.7	63,760.8
2.2	Хадгаламж	27,091.2	69,466.2
2.3	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	16,714.2	18,164.3
2.4	Бусад эх үүсвэр	1,311.5	792.5
2.5	Дериватив санхүүгийн өр төлбөр	0.0	0.0
2.6	Бусад санхүүгийн өр төлбөр	2,062.4	2,243.4
2.7	Бусад санхүүгийн бус өр төлбөр	488.0	193.8
2.8	Хоёрдогч өглөг	15,000.0	15,000.0
2.9	Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	0.0	0.0
	Нийт өр төлбөрийн дүн	175,356.0	169,621.0
3	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		
3.1	Хувь нийлүүлсэн хөрөнгө	35,130.0	35,130.0
3.2	Нэмж төлөгдсөн капитал	0.0	0.0
3.3	Халаасны хувьцаа	0.0	0.0
3.4	Дахин үнэлгээний нэмэгдэл	4,260.1	4,260.1
3.5	Хуримтлагдсан ашиг, алдагдал	-113,436.1	-106,741.8
3.6	Бусад өөрийн хөрөнгө	0.0	0.0
3.7	Өөрийн хөрөнгийн дүн	-74,046.0	-67,351.7
4	Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	101,310.0	102,269.3

ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

		Сая.Төгрөгөөр	
		2020/12/31	2021/12/31
	Орлого, зардлын зүйл	Өмнөх үеийн дүн	Тайлант үеийн дүн
1	Хүүгийн орлого	2,935.3	9,678.1
2	Хүүгийн зардал	7,969.0	2,864.8
3	Хүүгийн цэвэр орлого [(1)-(2)]	-5,033.7	6,813.3
4	Эрсдэлийн сангийн зардал	2,206.2	39,413.4
5	Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого [(3)-(4)]	-7,239.9	-32,600.1
6	Бусад орлого	26,292.2	46,055.2
6.1	<i>Хүүгийн бус орлого</i>	1,564.9	773.2
6.1.1	Арилжааны орлого	601.6	169.5
6.1.2	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого	0.0	494.4
6.1.3	Банкны бүтээгдэхүүн үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	963.4	109.2
6.1.4	Бусад хүүгийн бус орлого	0.0	0.0
6.2	<i>Бусад орлого, олз</i>	24,727.3	45,282.0
7	Бусад зардал	6,883.2	6,753.1
7.1	<i>Хүүгийн бус зардал</i>	5,707.7	6,112.0
7.1.1	Бусад эрсдэлийн сангийн зардал	49.8	1,486.3
7.1.2	Арилжааны зардал	55.0	162.6
7.1.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал	1,362.2	0.0
7.1.4	Хураамж, шимтгэлийн зардал	134.5	56.7
7.1.5	Үйл ажиллагааны бусад зардал	4,106.2	4,406.4
7.2	<i>Бусад зардал, гарз</i>	1,175.5	641.2
8	Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)	12,169.2	6,701.9
9	Орлогын татварын зардал	3.9	7.0
10	Татварын дараах ашиг, алдагдал (8-9)	12,165.3	6,695.0

ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Д/д	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	Байх ёстой	Банкны тайлангаар
			12/31/2021
1	<i>Өөрийн хөрөнгийн хүрэлцээ</i>		
	Өөрийн хөрөнгө, эрсдлээр жигнэсэн активын зохистой харьцаа (>12%)	12%	-42.5%
	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдлээр жигнэсэн активын зохистой харьцаа (>9%)	9%	-42.5%
2	<i>Зээлийн төвлөрлийн эрсдлийн үзүүлэлтүүд:</i>		
A	Нэг зээлдэгч, түүнд холбогдох этгээдэд олгосон зээл, батлан даалт, аккредитивын нийлбэр нь өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй		-4.7%
	Нийт зээлдэгч, түүнд холбогдох этгээдэд олгосон зээл, батлан даалт, аккредитивын нийлбэр		-11.2%
	Хувь нийлүүлэгч, банкны ажилтан, тэдгээрт холбогдох этгээдэд олгосон зээл, батлан даалт, аккредитивын: Нэг этгээдийн хувьд өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй		-0.2%
	Нийлбэр нь өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй		-0.2%
3	<i>Гадаад валютын актив, пассивын зохистой харьцаа</i>		
	Нэгж валютын хувьд (< +/- 15%)	15%	72.0%
	Нийт валютын хувьд (< +/- 40%)	40%	80.3%
4	<i>Үндсэн хөрөнгийн харьцаа (<8%):</i>	8%	15.7%
5	<i>Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа (>25%)</i>	25%	1.0%
6	<i>Зээл активын харьцаа</i>		66.5%

ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК ХХК

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Аудитлагдсан санхүүгийн тайлан
2021 оны 12 дугаар сарын 31

“Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банк” ХХК
Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын
дагуу бэлтгэгдсэн Санхүүгийн Тайлан болон
Хараат бус Аудиторын Тайлан
2021 оны 12 дугаар сарын 31



Агуулга

	Хуудас
Банкны Мэдээлэл	1
Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл	2
Хараат Бус Аудиторын Тайлан	3
Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан	6
Санхүүгийн Байдлын Тайлан	7
Өмчийн Өөрчлөлтийн Тайлан	8
Мөнгөн Гүйлгээний Тайлан	9
Санхүүгийн Тайлангийн Тодруулга	11



Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банк ХХК

Банкны Мэдээлэл

Албан ёсны хаяг

Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Усны
гудамж,
Үндэсний хөрөнгө оруулалтын
банкны төв байр

Хувьцаа эзэмшигч ид

Д. Дагвадорж (56.99%)
UB Diversified ltd (5.33%)
Д. Сумъяабазар (15.99%)
Б.Баярсайхан (15.99%)
Ч.Маралмаа (5.70%)

Төлөөлөн Удирдах Зөвлөл

С. Оргилмаа
Б. Тулга
Хидетоши Тонока
П.Ариунаа
Ж.Цэдэнрагчаа

Гүйцэтгэх захирлын орлогч
Санхүү, бүртгэл, тайлагналын газрын
захирал

Г. Тогтохбаатар
А. Удвал

Хараат бус аудитор

Шонхор үнэлгээ Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар,
Сүхбаатар дүүрэг, 6 дугаар
хороо, 13 дугаар барилга,
603 тоот



“Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банк”
ХХК-ийн хувьцаа эзэмшигчидэд

“ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ” ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
6 дугаар хороо, Метро би шес оффис,
6 дугаар давхар 603 тоот

Утас: 70150001, 80110088

Цахим шуудан: www.shonkhor.mn

И-мэйл: shonkhor.mn@gmail.com

2022.03.30

№

2022/36

танай _____ -ны № _____ -т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай Дүгнэлт

Бид Үндэсний хөрөнгө оруулалтын банк (“Компани”)-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр нэрлэсэнээс үүссэн нөлөөнөөс бусдаар санхүүгийн тайлангууд нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай Дүгнэлтийн Үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)-уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Онцлох Асуудал – Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Өмчийн өөрчлөлтийн тайланд анхаарлаа хандуулж байна. Банкны 2021 онд цэвэр ашиг 6,694,959.4 мян.төг, (2020 онд ашиг 12,163,308.4 мян.төг) байгаа хэдий ч өнөөдрийг хүртэл нийт өр төлбөрийн дүн нь нийт өөрийн хөрөнгөөс 67,351,660.2 мян.төг (2020 онд 74,045,968.2 мян.төг)-өөр давсан байна.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бусад асуудал – Болзошгүй өр төлбөр, эрсдэл

Банк нь томоохон дүнтэй зээлийн эргэн төлөлтийн хангалтгүй байдал, зээлийн барьцааны дутагдал зэргээс их хэмжээний алдагдал хүлээн зөвшөөрч болзошгүй байна.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, төлбөр гүйцэтгэлийн саатлаас хамааран төлбөр гүйцэтгэлийн эрсдэлд орж болзошгүй. Мөн банкны эзэмшлийн биет болон биет бус хөрөнгүүдтэй холбоотой хийгдсэн дахин үнэлгээний үр дүн, тэдгээртэй холбоотой залруулах бичилтийн нөлөөг дурдах нь зүйтэй.

Бид уг асуудлыг удирдлагын анхааралд хүргэж байгаа бөгөөд, энэхүү асуудлаар дүгнэлтээ өөрчлөөгүй болно.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг дүнг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага /үргэлжлэл/

- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

Бусад

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол улсын Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасны дагуу компанийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчид зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд аливаа гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ ХХК



Даваажавын Шийрэв,
Гүйцэтгэл захирал

Огноо: 2022 оны 03 дугаар сарын 30

Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 6-р хороо,
13-р байр, Метро бизнес төв, 603 тоот



“Үндэсний Хөрөнгө Оруулалтын
Банк” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын
орлогч Г.Тогтохбаатар танаа

“ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ” ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
6 дугаар хороо, Метро бизнес оффис,
6 дугаар давхар 603 тоот

Утас: 70150001, 80110088

Цахим шуудан: www.shonkhor.mn

И-мэйл: shonkhor.mn@gmail.com

2022.03.30 № 22/34
танай _____-ны № _____-г

Менежментийн захидал

Аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурьдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Илрүүлэлт: Банкны дүрмийн сан холбогдох хууль, журмын шаардлагыг хангаагүй хэвээр байгаа.

Өгсөн зөвлөмж: Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А-276 тоот тушаалаар банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс 100.0 (зуун) тэрбум төгрөг болгож тогтоох шаардлагыг хангаагүй байгаа тул холбогдох арга хэмжээг авах.

2. Илрүүлэлт: Нийт зээлийн үлдэгдлийн 95 орчим хувьд зээлийн барьцааны түүвэр шалгалт хийхэд 25,140,158.7 мян.төгрөгийн зээлүүд барьцаагүй, барьцааны гэрээ хийгдсэн ч холбогдох бүртгэх байгууллагад бүртгэгдээгүй.

Өгсөн зөвлөмж: Дээр дурдсан зээлүүдийг барьцаагаар хангуулах, яаралтай эргэн төлүүлэх арга хэмжээ авах

3. Илрүүлэлт: Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний үр дүнгээр санхүүгийн тайланд холбогдох бичилт хийгээгүй.

Энэ нь 2021 оны 6 дугаар сард хөрөнгийн үнэлгээний хараат бус байгууллага болох “Бэйкер Тилли Далай ван Такс ТМЗ” ХХК-иар гүйцэтгүүлсэн Хөрөнгийн дахин үнэлгээний тайланд банкны өмчлөлийн Ү-2203022378 бүртгэлийн дугаартай 1728.6 мк хэмжээтэй оффисын зориулалттай барилга 14,428,320.0 мян.төгрөгөөр, 0019238 гэрчилгээний дугаартай газар эзэмших эрх 19,067,110 мян.төгрөгөөр тус тус үнэлэгдсэн боловч санхүүгийн тайланд дахин үнэлэгдсэн дүнг шинэчлэн тусгаагүй.

Өгсөн зөвлөмж: НББОУС 16, НББОУС 38 дахь стандартуудад заасныг удирдлага болгон санхүүгийн тайланд бүртгэх.

4. Илрүүлэлт: Банкны үйл ажиллагааны зохистой харьцаанууд алдагдсан, түүний дотор төлбөр түргэн гүйцэтгэх чадвар эрсдэлтэй хэвээр.

Өгсөн зөвлөмж: Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллах талаар холбогдох арга хэмжээнүүдийг авах.

Дээр дурьдсан зөвлөмжүүдийг судалж хууль тогтоомжийн дагуу холбогдох шийдвэрийг гаргасны үндсэн дээр хэрэгжүүлж ажиллана уу.

Банкнаас тусгайлан тодруулсан ажил гүйлгээний талаар:

Банкны санхүүгийн тайлангийн Бусад санхүүгийн бус хөрөнгө гэсэн ангилалд 56,802.75 сая. төгрөгийн (73,485.25 сая.төг - 16,682.5 сая.төг) борлуулах зориулалттай хөрөнгө цэвэр дүнгээрээ бүртгэгдсэн байгаа юм.

Энэ нь Эргэлтийн хөрөнгийн ангилалд байгаа бөгөөд эдгээр хөрөнгийг борлуулж холбогдох этгээдүүдийн чанаргүй зээлээр хаах зорилготой ТУЗ-ийн 2021 оны 21-38 дугаар тогтоолын дагуу хүлээн авсан. Эдгээр хөрөнгүүд нь хөндлөнгийн хөрөнгийн үнэлгээний байгууллагаар 73,485.25 сая.төгрөгөөр үнэлэгдсэн.

Банк хөрөнгийн үнэлгээний тайланг үндэслэн 73,485.25 мян.төгрөгөөр санхүүгийн тайланд бүртгэж банкны холбоотой этгээдэд хамаарах зээлүүдийг хаахаар шийдвэрлэж Монголбанкинд холбогдох хүсэлтийг тавьсан. Монголбанкнаас ирүүлсэн албан бичгээр энэ дүнгээс 56,802.75 сая.төгрөгийн зээлүүдийг хаахыг зөвшөөрч үлдэх 16,682.5 сая.төг төгрөгийн дүнг эрсдэлийн сан(үнэ цэнийн бууралт)-ийн дансанд тусгах чиглэлийг албан бичгээр өгсөн. Өөрөөр хэлбэл дараах бичилт хийхийг албан бичгээр зөвлөж үүрэг болгосон.

Үүнд:

Дт Бусад санхүүгийн бус хөрөнгө 73,485.25 сая төг

Кт Зээлүүд 56,802.75 сая.төг

Кт эрсдэлийн сан(балансын данс) 16,682.50 сая.төг

Харин банкны зүгээс Борлуулах зорилготой үл хөдлөх хөрөнгийн данс бүртгэлд авсан дүн хаагдсан зээлүүдийн дүн хоёрын зөрүүгээр үнэ цэнийн бууралт бус холбоотой этгээдүүдэд өглөг үүсгэж бүртгэх эсэх асуудлыг тодруулсан.

СТОУС 5-д Борлуулах зорилготой үл хөдлөх хөрөнгийн үнийн дүнг хүлээн зөвшөөрөхдөө түүний дансны үнэ ба борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнэ хоёрын аль багаар нь тооцохыг заасан байдаг.

Үндэсний хөрөнгө оруулалтын банкны хувьд банкны үйл ажиллагаа хүндэрч Монголбанкны төлөөлөгчид томилогдон ажиллаж байгаа, банкны зарим үйл ажиллагаанд шууд хязгаарлалт хийгдсэн, томилогдсон албан тушаалтнуудын хууль, тогтооноор зөвшөөрөгдсөн оролцоо өндөр байгаа зэрэг онцлогтой байгууллага юм. Энэ утгаараа банкны холбогдох этгээдүүдтэй хийгдсэн сонирхолын зөрчилтэй энэхүү хэлцлийн үр дүнгээр хаагдах зээлүүдийн хэмжээг тогтоохдоо банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор тодорхой хязгаарлалт, зохицуулалт хийсэн гэдгээ тайлбарласан. Тухайлбал Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн А-192 дугаар тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаваруудын дотор “Монгол банкны хянагч банкинд эрсдэлтэй, хохиролтой байж болзошгүй гэж үзсэн хэлцэл, гүйлгээг хийхгүй байх” гэсэн заалт байгаа юм. Энэ нь банкны хувьд бие даан асуудлаа шийдвэрлэх эрхийг нь хязгаарласныг илэрхийлж байна.

Гэхдээ Монголбанкны зүгээс тухайн хөрөнгийг яаралтай борлуулах, борлуулалт хэрэгжих үнийн дүнгээс хамаарч хийгдэх дараагийн алхамуудыг нээлттэй үлдээсэн байна. Банкны зүгээс энэхүү зөрүүг өглөг хэлбэрээр бүртгэсэн ч санхүүгийн үр ашигт нөлөөлөхгүй юм. Өөрөөр хэлбэл дараах бичилт хийгдэнэ. Үүнд:

Дт эрсдэлийн сан(балансын данс) 16,682.50 сая.төг

Кт Холбоотой этгээдэд өгөх өглөг 16,682.50 сая.төг

Дээрх бичилтийн үр дүнд санхүүгийн тайлангийн нийт дүнд дурьдагдсан дүнгээр өсөх бөгөөд ашиг алдагдалд ямар ч нөлөө үзүүлэхгүй бөгөөд харин уг хөрөнгүүдийг Монголбанкны өмнөх зээл хаахыг зөвшөөрсөн дүнгээс илүү үнээр худалдан борлуулаад холбоотой этгээдүүдийн зээлүүдээс хаасан тохиолдолд нэгэнт өмнө нь байгуулагдсан зээлийн эрсдэлийн сангаас зохих дүнгээр тайлант жилийн эрсдэлийн сангийн зардлыг бууруулж ашгийн хэмжээг нэмэгдүүлэх боломжтой.

Иймээс энэ асуудлын хувьд борлуулах зорилгоор эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийг яаралтай худалдан борлуулах арга хэмжээ авсны үндсэн дээр Монголбанкинд хандаж дараагийн алхамуудыг авч ажиллах нь зохимжтой.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.ШИЙРЭВ



2022 оны 3 дугаар сарын 30-ны өдөр



ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК ХХК

Санхүүгийн Байдлын Тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

	Тодруулга	2021 мян.төг	2020 мян.төг
ХӨРӨНГӨ			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө		1,674,996.2	2,004,434.0
Хөрөнгө оруулалт	11	2,344,036.1	2,538,647.4
Арилжааны үнэт цаас		0.0	0.0
Борлуулахад бэлэн үнэт цаас		7,532,904.4	7,535,004.4
Үнэт цаасны эрсдэлийн сан		(5,188,868.3)	(4,996,357.0)
Зээл (цэвэр дүнгээр)		6,986,430.4	29,605,653.4
Хэвийн зээл		1,469,041.8	5,620,916.2
Хугацаа хэтэрсэн зээл		3,276.3	3,749,562.6
Хэвийн бус зээл		398,931.6	16,824,291.3
Эргэлзээтэй зээл		4,824,586.5	8,151,834.2
Муу зээл		61,306,616.3	59,543,144.5
Зээлийн хойшлогдсон төлбөр		(6,047.0)	(12,860.6)
Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага		196,467.6	1,579,536.2
Зээлийн эрсдэлийн сан		(61,206,442.9)	(65,850,771.0)
Бусад санхүүгийн хөрөнгө		297.9	30,909,681.9
Бусад санхүүгийн бус хөрөнгө		58,673,389.9	1,027,617.8
Үндсэн хөрөнгө	12	10,599,238.7	11,577,082.6
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		2,069,725.2	2,123,234.9
Борлуулах зориулалттай хөрөнгө		3,401,532.3	4,956,347.3
Биет бус хөрөнгө	13	16,519,654.9	16,567,337.7
Нийт хөрөнгийн дүн		102,269,301.5	101,310,037.1
ӨР ТӨЛБӨР			
Харилцах		63,760,842.6	112,688,710.5
Харилцах дансны нэрлэсэн үлдэгдэл		63,760,842.5	112,688,022.2
Харилцах дансанд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг		0.1	688.3
Хадгаламж		69,466,153.9	27,091,185.0
Хугацаагүй хадгаламж		14,970,454.9	6,857,513.2
Хугацаатай хадгаламж		53,868,378.8	19,421,954.0
Бусад төрлийн хадгаламж		-	-

Хадгаламжинд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг		627,320.3	811,717.8
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	15	18,164,290.4	16,714,162.7
Бусад эх үүсвэр	16	792,495.7	1,311,548.7
Бусад санхүүгийн өр төлбөр	17	2,243,427.8	2,062,447.3
Бусад санхүүгийн бус өр төлбөр		193,751.3	487,951.0
Хоёрдогч өглөг		15,000,000.0	15,000,000.0
Нийт өр төлбөрийн дүн		169,620,961.8	175,356,005.3
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
Хувь нийлүүлсэн хөрөнгө	18	35,130,000.8	35,130,000.8
Давуу эрхийн хувьцаа		0.0	0.0
Энгийн хувьцаа		35,130,000.8	35,130,000.8
Дахин үнэлгээний нэмэгдэл		4,260,124.7	4,260,124.7
Хуримтлагдсан ашиг, алдагдал		(106,741,785.7)	(113,436,093.7)
Өөрийн хөрөнгийн дүн		(67,351,660.2)	(74,045,968.2)
Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн		<u>102,269,301.5</u>	<u>101,310,037.1</u>





ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК ХХК

Орлогын Тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил

	Тодруулга	2021 мян.төг	2020 мян.төг
Хүүгийн орлого	1	9,678,115.3	2,935,255.6
Монголбанкинд байршуулсан хөрөнгийн		-	-
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн		(9,977.0)	188,456.4
Үнэт цаасны		149,546.6	147,856.5
Зээлийн		9,538,545.7	2,598,942.6
Хүүгийн зардал	2	2,864,834.0	7,968,992.4
Харилцахад төлсөн хүү		3,181.3	2,195,538.9
Хадгаламжинд төлсөн хүү		2,339,216.5	4,656,012.8
Зээлийн хүүгийн зардал		509,219.4	391,630.7
Үнэт цаасны хүүгийн зардал		-	706,001.0
Бусад хүүгийн зардал		13,216.8	19,808.9
ЦЭВЭР ХҮҮГИЙН ОРЛОГО(1-2)		6,813,281.2	(5,033,736.8)
Эрсдэлийн сангийн зардал		39,413,395.1	2,206,150.1
Үнэт цаасны		648,771.2	925,425.7
Зээлийн		38,764,623.9	1,280,724.4
Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого [(3)-(4)]		(32,600,113.8)	(7,239,886.9)
Бусад орлого	5	90,391,196.4	88,803,603.4
Арилжааны орлого		169,486.3	601,554.1
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого		44,830,477.6	62,511,366.7
Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого		109,222.4	963,351.5
Бусад орлого, олз		45,282,009.9	24,727,331.0
Бусад зардал	6	51,089,153.4	69,394,517.4
Хүүгийн бус зардал			
Бусад эрсдэлийн сангийн зардал		1,486,298.8	49,750.4
Арилжааны зардал		162,598.9	55,008.9
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал		44,336,028.9	63,873,528.4
Хураамж, шимтгэлийн зардал		56,657.5	134,532.7
Үйл ажиллагааны бусад зардал		4,406,415.6	4,106,204.4
Бусад зардал, гарз		641,153.6	1,175,492.5
Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)		6,701,929.2	12,169,308.4
Орлогын татварын зардал	10	6,969.7	3,890.8
Татварын дараах ашиг, алдагдал (8-9)		6,694,959.4	12,165,308.4
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)		6,694,959.4	12,165,308.4
Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (12+13)		6,694,959.4	12,165,308.4





ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК ХХК

Өмчийн Өөрчлөлтийн Тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил (мян.төгрөгөөр)

Үзүүлэлт	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Нэмж төлөгдсөн капитал	Халаасны хувьцаа	Дахин үнэлгээний нэмэгдэл	Бусад өөрийн хөрөнгө	Хуримт-лагдсан ашиг	Нийт Дүн
2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	35,130,000.8	0.0	0.0	4,260,124.7	0.0	(106,741,785.7)	(67,351,660.2)
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	0.0	0.0	0.0	0.0	0.0	6,694,959.4	6,694,959.4
Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2020 оны 12-р сарын 31-ны залруулсан үлдэгдэл	35,130,000.8	0.0	0.0	4,260,124.7	0.0	(113,436,745.2)	(74,046,619.7)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.0	0.0	0.0	0.0	0.0	(651.5)	(651.5)
2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	35,130,000.8	0.0	0.0	4,260,124.7	0.0	(113,436,093.7)	(74,045,968.2)
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	0.0	0.0	0.0	0.0	0.0	12,165,308.4	12,165,308.4
2019 оны 12-р сарын 31-ны залруулагдсан үлдэгдэл	35,130,000.8	0.0	0.0	4,260,124.7	0.0	(125,601,402.1)	(86,211,276.6)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.0	0.0	0.0	0.0	0.0	(529,101.3)	(529,101.3)
2019 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	35,130,000.8	0.0	0.0	4,260,124.7	0.0	(125,072,300.8)	(85,682,175.3)



ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК ХХК

Мөнгөн Гүйлгээний Тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жил



Үзүүлэлт	Тодруулга	2021 мян.төг	2020 мян.төг
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал)		6,701,929.2	12,169,199.2
Орлого, зардлын тохируулга		4,293,827.1	(14,180,360.8)
Эрсдэлийн сангийн зардал (+)		57,368,079.0	2,255,900.6
Элэгдэл, хорогдлын зардал (+)		781,046.9	806,161.9
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого (-), зардал (+) (Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөөс бусад)		(494,448.7)	1,362,161.6
Хуримтлуулсан хүүгийн орлого (-)		(9,678,115.3)	(2,935,255.6)
Хуримтлуулсан хүүгийн зардал (+)		2,864,834.0	7,968,992.4
Хөрөнгө данснаас хассаны олз (-), гарз (+)		93,287.4	906,357.6
Бусад олз (-), гарз (+)		(46,640,856.3)	(24,544,679.3)
Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн тохируулга		(15,481,210.3)	(26,286,158.2)
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)		-	-
Арилжааны үнэт цаасны өсөлт (-), бууралт (+)		-	-
Зээлийн өсөлт (-), бууралт (+)		25,887,296.1	13,956,515.0
Бусад санхүүгийн хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)		30,909,384.1	-23,702,610.9
Бусад санхүүгийн бус хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)		(72,559,342.2)	12,542,132.4
Харилцах, хадгаламжийн өсөлт(+), бууралт(-)		(6,367,813.2)	(33,764,818.5)
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн өсөлт (+), бууралт (-)		6,762,484.2	13,828,583.2
Бусад санхүүгийн өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)		180,980.4	421,454.6
Бусад санхүүгийн бус өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)		(294,199.7)	(9,567,414.0)
Бусад тохируулга		6,778,618.2	(7,234,453.5)
Авсан хүү (+)		9,678,115.3	2,569,666.6
Төлсөн хүү (-)		(2,864,834.1)	(9,520,868.1)

Эрсдлийн сангаас хаасан олз, гарз	(27,849.4)	(256,615.6)
Бусад	(6,813.6)	(22,745.7)
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	2,293,164.2	(35,531,773.4)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	2,100.0	(125,500.0)
Борлуулахад бэлэн үнэт цаас борлуулсны орлого	2,100.0	(125,500.0)
Мөнгөн зарлагын дүн (-)	(1,910,583.7)	(7,415,939.5)
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(1,147,741.9)	(872,269.6)
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(762,841.7)	(6,543,670.0)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,908,483.7)	(7,541,439.6)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	(15,303.0)	11,432,835.2
Бусад эх үүсвэр татахад	(15,303.0)	(203,371.9)
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Хоёрдогч өглөгөөс хүлээн авсан	-	11,636,207.1
Бусад	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	(503,750.0)	(407,231.9)
Бусад эх үүсвэрт төлсөн	(503,750.0)	(407,231.9)
Бусад	0.0	0.0
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(519,053.0)	11,025,603.3
Валютын ханшийн зөрүү	(195,065.3)	249,364.8
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(329,437.8)	(31,798,244.8)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,004,434.0	33,802,678.8
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,674,996.2	2,004,434.0





*Итгэлд дөрөөлсөн
Их үйлсийн ПҮНШ*

*Хаяг: УБ, СБД, 3-р хороо, Усны
гудамж -1 Үндэсний хөрөнгө
оруулалтын банк*

Холбоо барих: 1800-1188

 **NIBank**
ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК